

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/18 /НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх	Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Б.Батмөнх Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2024 он	Утас: 7036-3036 Ахлах аудитор: Утас: 7036-2442	Ц.Ундраа Цахим хаяг: <a href="mailto:undraats@audit.gov.mn">undraats@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	18
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20-21
5. Аудитын илрүүлэлт	23
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

САЙХАН СУМЫН СУМ ДУНДЫН  
ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА  
Х.АЛТАНХУЯГ ТАНАА

2024.2.23 № САА-2024/18-НД-СН-АУЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

ЦЕГ-ын даргын 2023 оны 2/352, Санхүү, ар талын албаны даргын 2023 оны 16/2918 дугаар албан бичгүүдээр “Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон “Ахмадын сан”-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах” гэж үүрэг, чиглэл өгсний дагуу цалингийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 25,509.0 мянган төгрөгийг Ахмадын сангийн 100130912503 дугаар дансанд шилжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Сайхан сумын Сум дундын Цагдаагийн хэлтэс нь ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар баталсан цагдаа, дотоодын

цэргийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа нь түүнээс хойш нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт орсон нэмэлт өөрчлөлтүүдтэй нийцэхгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Сайхан сумын Сум дундын Цагдаагийн хэлтэс нь тайлант онд "Цагдаа дотоодын цэргийн байгууллагын мэдээлэл харилцаа холбоо цахим технологийн ашиглалтыг нэмэгдүүлж үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангана алба хаагчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж менежментийн шинэлэг арга хэлбэрийг нэвтрүүлэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ " зорилго дэвшүүлж 5 зорилт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.2 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>91,168,570.71</b>	<b>119,953,526.87</b>
<b>2</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>10,533,165.10</b>	<b>30,457,179.45</b>
3	Банк-д байгаа бэлэн мөнгө	10,533,165.10	30,457,179.45
4	Төгрөг	10,533,165.10	30,457,179.45
5	Төрийн сангийн харилцах	10,533,165.10	30,457,179.45
<b>6</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,675,542.00</b>	<b>3,776,547.31</b>
7	Ажиллагчидтай холбогдсон авлага		101,005.31
8	Бусад авлага	3,675,542.00	3,675,542.00
9	Хувь хүмүүсээс авах авлага	3,675,542.00	3,675,542.00
<b>10</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>76,959,863.61</b>	<b>85,719,800.11</b>
11	Түүхий эд материал	44,962,821.61	59,331,816.11
12	Тусгай зориулалттай материал	43,668,821.61	57,857,816.11
13	Эм боох материал	1,294,000.00	1,474,000.00
14	Бэлэн бүтээгдэхүүн		400,000.00
15	Хангамжийн материал	29,090,666.00	23,360,269.00
16	Бичиг хэргийн материал	9,878,950.00	6,062,050.00
17	Аж ахуйн материал	14,294,821.00	11,650,171.00
18	Түлш, шатах тослох материал	2,826,747.00	3,113,268.00
19	Барилгын засварын материал	1,342,000.00	1,902,000.00
20	Бусад хангамжийн материал	748,148.00	632,780.00
21	Мал амьтад	2,906,376	2,627,715.00
<b>22</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>470,693,315.13</b>	<b>2,755,720,447.37</b>
<b>23</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>470,693,315.13</b>	<b>2,755,720,447.37</b>
24	Биет хөрөнгө	451,483,774.93	2,736,715,020.57
25	Барилга, байгууламж, орон сууц	433,406,450.00	2,738,054,649.00
26	Хуримтлагдсан элэгдэл	-33,190,547.12	-43,731,717.24
27	Авто-тээврийн хэрэгсэл	76,744,035.04	76,744,035.04
28	Хуримтлагдсан элэгдэл	-74,494,035.04	-76,744,035.04
29	Машин тоног төхөөрөмж(компьютер)	88,166,447.85	82,714,780.85
30	Хуримтлагдсан элэгдэл	-44,760,645.20	-44,396,424.24
31	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,474,388.20	13,898,482.20

32	Хуримтлагдсан элэгдэл	-15,862,318.60	-9,824,749.80
33	Биет бус хөрөнгө	19,209,540.20	19,005,426.80
34	Программ хангамж	1,020,567.00	1,020,567.00
35	Хуримтлагдсан элэгдэл	-408,226.80	-612,340.20
36	Бусад биет бус хөрөнгө	18,597,200	18,597,200.00
<b>37</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>561,861,885.84</b>	<b>2,875,673,974.24</b>
<b>38</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>42,947.20</b>	<b>253,446.26</b>
<b>39</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>42,947.20</b>	<b>253,446.26</b>
40	Өглөг	42,947.20	253,446.26
41	Ажилчидтай холбогдсон өглөг	42,947.20	253,446.26
<b>42</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>561,818,938.64</b>	<b>2,875,420,527.98</b>
43	Засгийн газрын хувь оролцоо	561,818,938.64	2,875,420,527.98
44	Засгийн газрын оруулсан капитал	313,667,225.00	313,667,225.00
45	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	313,667,225.00	313,667,225.00
46	Хуримтлагдсан үр дүн	107,059,438.44	2,420,661,027.78
47	Өмнөх үеийн үр дүн	118,493,737.39	107,059,438.44
48	Тайлант үеийн үр дүн	-11,434,298.95	2,313,601,589.34
49	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	141,092,275.20	141,092,275.20
<b>50</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>561,861,885.84</b>	<b>2,875,673,974.24</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,053,941,614.00</b>	<b>3,930,905,535.00</b>
<b>2</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,519,514.00</b>	<b>2,334,506,235.00</b>
3	Нийтлэг татварын бус орлого	23,519,514.00	2,334,506,235.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,878,653.00	5,796,436.00
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,582,400.00	5,269,500.00
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,637,200.00	
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,659,053.00	526,936.00
8	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,873,831.00	2,313,558,199.00
9	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,767,030.00	15,151,600.00
<b>10</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,030,422,100.00</b>	<b>1,596,399,300.00</b>
11	Улсын төвлөрсөн төсвөөс	1,026,738,900.00	1,595,034,000.00

12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,026,738,900.00	1,595,034,000.00
13	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,683,200.00	1,365,300.00
14	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,300,000.00	
15	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,383,200.00	1,365,300.00
<b>16</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,065,375,912.95</b>	<b>1,617,303,945.66</b>
<b>17</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,065,375,912.95</b>	<b>1,617,303,945.66</b>
<b>18</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,057,082,016.95</b>	<b>1,468,218,295.66</b>
<b>19</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>823,636,868.98</b>	<b>1,238,681,752.58</b>
20	Үндсэн цалин	506,387,737.78	752,064,546.57
21	Нэмэгдэл	281,031,034.20	433,584,937.16
22	Унаа хоолны хөнгөлөлт	19,095,000.00	23,518,000.00
23	Урамшуулал	17,123,097.00	29,514,268.85
<b>24</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,949,049</b>	<b>24,882,399.44</b>
25	Тэтгэврийн даатгал	1,154,526.36	187,269.41
26	Тэтгэмжийн даатгал	135,828.11	22,031.69
27	ҮОМШӨ-ний даатгал	108,662.49	17,625.37
28	Ажилгүйдлийн даатгал	27,165.62	4,406.33
29	Эрүүл мэндийн даатгал	16,522,866.42	24,651,066.64
<b>30</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>78,049,436.00</b>	<b>88,143,419.00</b>
31	Гэрэл, цахилгаан	16,945,632.80	12,981,700.00
32	Түлш, халаалт	57,873,289.20	71,674,700.00
33	Цэвэр, бохир ус	3,230,514.00	3,487,019.00
<b>34</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>53,634,421.12</b>	<b>56,433,944.38</b>
35	Бичиг хэрэг	8,468,400.00	8,723,700.00
36	Тээвэр, шатахуун	32,905,690.00	34,362,933.00
37	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,787,571.12	3,219,154.38
38	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	153,600.00
39	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,846,390.00	3,182,150.00
40	Бараа материал акталсны зардал	3,426,370.00	6,792,407.00
<b>41</b>	<b>Норматив зардал</b>	<b>4,771,930.00</b>	<b>5,309,888.00</b>
42	Хоол, хүнс	4,771,930.00	5,309,888.00

43	Эд хогшил, урсгал засварын зардал	16,047,250	11,128,440.00
44	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,636,000	1,364,750.00
45	Урсгал засвар	13,411,250	9,763,690.00
46	Томилолт, зочны зардал	6,095,000	1,060,000.00
47	Дотоод албан томилолт	6,095,000	1,060,000.00
48	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,832,449	9,882,278.00
49	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,059,301	5,103,000.00
50	Тээврийн хэрэгслийн татвар	534,300	520,910.00
51	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000	143,000.00
52	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,000,000.00
53	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	95,848	115,368.00
54	Бараа үйлчилгээний бусад зардал	54,065,612.85	32,696,174.26
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,991,700	625,107.50
56	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,073,912.85	32,071,066.76
57	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,293,896	149,085,650.00
58	Бусад урсгал шилжүүлэг	3,377,000	146,299,800.00
59	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		63,675,700.00
60	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		40,715,114.40
61	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,377,000	41,908,985.60
62	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,916,896	2,785,850.00
63	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,916,896	2,784,800.00
64	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,050.00
65	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-11,434,298.95	2,313,601,589.34
66	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-11,434,298.95	2,313,601,589.34

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,049,224,161.10	1,627,177,814.35
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,802,061.10	30,778,514.35
3	Нийтлэг татварын бус орлого	18,802,061.10	30,778,514.35
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,802,061.10	30,778,514.35

5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,916,896.00	5,269,500.00
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,885,165.10	25,509,014.35
<b>7</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,030,422,100.00</b>	<b>1,596,399,300.00</b>
8	Улсын төвлөрсөн төсвөөс	1,026,738,900.00	1,595,034,000.00
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,026,738,900.00	1,595,034,000.00
10	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,683,200.00	1,365,300.00
11	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,300,000.00	
12	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,383,200.00	1,365,300.00
<b>13</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,028,278,007.00</b>	<b>1,603,713,800.00</b>
<b>14</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,028,278,007.00</b>	<b>1,603,713,800.00</b>
<b>15</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,016,637,311.00</b>	<b>1,452,128,150.00</b>
<b>16</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>826,902,900.00</b>	<b>1,256,519,000.00</b>
17	Үндсэн цалин	472,858,681.66	737,092,596.27
18	Нэмэгдэл	325,561,942.27	468,843,675.93
19	Унаа хоолны хөнгөлөлт	11,739,366.00	22,942,273.05
20	Урамшуулал	16,742,910.07	27,640,454.75
<b>21</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,024,600.00</b>	<b>26,078,100.00</b>
22	Эрүүл мэндийн даатгал	18,024,600.00	26,078,100.00
<b>23</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>78,029,500.00</b>	<b>88,397,800.00</b>
24	Гэрэл, цахилгаан	16,945,632.80	12,981,700.00
25	Түлш, халаалт	57,873,289.20	71,869,700.00
26	Цэвэр, бохир ус	3,210,578.00	3,546,400.00
<b>27</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>53,245,400.00</b>	<b>44,555,700.00</b>
28	Бичиг хэрэг	11,524,300.00	4,124,800.00
29	Тээвэр, шатахуун	31,963,600.00	34,769,100.00
30	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,812,600.00	3,276,400.00
31	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	153,600.00
32	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,744,900.00	2,231,800.00
<b>33</b>	<b>Норматив зардал</b>	<b>5,543,800.00</b>	<b>5,450,000.00</b>
34	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	742,800.00	180,000.00
35	Хоол, хүнс	4,302,700.00	4,870,000.00
36	Нормын хувцас, зөөлөн эдлэл	498,300.00	400,000.00
<b>37</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,804,011.00</b>	<b>15,754,250.00</b>
38	Багаж, техник, хэрэгсэл	3,887,011.00	3,760,000.00

39	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,419,500.00	1,584,250.00
40	Урсгал засвар	13,497,500.00	10,410,000.00
<b>41</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,118,500.00</b>	<b>1,060,000.00</b>
42	Дотоод албан томилолт	6,118,500.00	1,060,000.00
<b>43</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,952,300.00</b>	<b>13,576,700.00</b>
44	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,134,700.00	8,480,000.00
45	Тээврийн хэрэгслийн татвар	534,300.00	810,200.00
46	Тээврийн хэрэгслийн оношилгоо	283,300.00	286,500.00
47	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,000,000.00
<b>48</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,016,300.00</b>	<b>736,600.00</b>
49	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,016,300.00	736,600.00
<b>50</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,640,696.00</b>	<b>151,585,650.00</b>
<b>51</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,723,800.00</b>	<b>148,799,800.00</b>
52	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,345,300.00	1,000,000.00
53	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		63,675,700.00
54	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		45,239,100.00
55	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,378,500.00	38,885,000.00
<b>56</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,916,896.00</b>	<b>2,785,850.00</b>
57	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,916,896.00	2,784,800.00
58	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,050.00
<b>59</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>20,946,154.10</b>	<b>23,464,014.35</b>
<b>60</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>10,412,989.00</b>	<b>3,540,000.00</b>
<b>61</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,412,989.00</b>	<b>3,540,000.00</b>
62	Дотоод эх үүсвэрээр	10,412,989.00	3,540,000.00
63	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,412,989.00	3,540,000.00
<b>64</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-10,412,989.00</b>	<b>-3,540,000.00</b>
<b>65</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>10,533,165.10</b>	<b>19,924,014.35</b>
<b>66</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>10,533,165.10</b>
<b>67</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>10,533,165.10</b>	<b>30,457,179.45</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>313,667,225.00</b>	<b>141,092,275.20</b>	<b>118,493,737.39</b>	<b>573,253,237.59</b>
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	313,667,225.00	141,092,275.20	118,493,737.39	573,253,237.59
3	Тайлант үеийн үр дүн			-11,434,298.95	-11,434,298.95
4	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>313,667,225.00</b>	<b>141,092,275.20</b>	<b>107,059,438.44</b>	<b>561,818,938.64</b>
5	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>313,667,225.00</b>	<b>141,092,275.20</b>	<b>107,059,438.44</b>	<b>561,818,938.64</b>
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	313,667,225.00	141,092,275.20	107,059,438.44	561,818,938.64
7	Тайлант үеийн үр дүн			2,313,601,589.34	2,313,601,589.34
8	<b>2023 оны 6-р сарын 30-нээрх үлдэгдэл</b>	<b>313,667,225.00</b>	<b>141,092,275.20</b>	<b>2,420,661,027.78</b>	<b>2,875,420,527.98</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,597,635,000.00</b>	<b>1,597,518,700.00</b>	<b>116,300.00</b>	99.9
2	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,597,635,000.00</b>	<b>1,597,518,700.00</b>	<b>116,300.00</b>	99.9
3	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,454,420,200.00</b>	<b>1,454,303,900.00</b>	<b>116,300.00</b>	99.9
4	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,256,519,000.00</b>	<b>1,256,519,000.00</b>		100
5	Үндсэн цалин	791,961,700.00	737,092,596.27	54,869,104.00	93.0
6	Нэмэгдэл	437,757,300.00	468,843,675.93	-31,086,376.00	107
7	Унаа хоолны хөнгөлөлт	19,440,000.00	22,942,273.05	-3,502,273.00	118
8	Урамшуулал	7,360,000.00	27,640,454.75	-20,280,455.00	375
9	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,078,100.00</b>	<b>26,078,100.00</b>	<b>0</b>	<b>100</b>
10	Эрүүл мэндийн даатгал	26,078,100.00	26,078,100.00	0	100
11	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>88,397,800.00</b>	<b>88,397,800.00</b>	<b>0</b>	<b>100</b>
12	Гэрэл, цахилгаан	12,981,700.00	12,981,700.00	0	100
13	Түлш, халаалт	71,869,700.00	71,869,700.00	0	100
14	Цэвэр, бохир ус	3,546,400.00	3,546,400	0	100
15	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>44,025,700.00</b>	<b>44,025,700.00</b>	<b>0</b>	<b>100</b>

16	Бичиг хэрэг	4,124,800.00	4,124,800.00	0	100
17	Тээвэр, шатахуун	34,239,100.00	34,239,100.00	0	100
18	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,276,400.00	3,276,400.00	0	100
19	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	153,600.00	153,600.00	0	100
20	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,231,800.00	2,231,800.00	0	100
<b>21</b>	<b>Норматив зардал</b>	<b>5,450,000.00</b>	<b>5,450,000.00</b>	<b>0</b>	<b>100</b>
22	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	180,000.00	180,000.00	0	100
23	Хоол, хүнс	4,870,000.00	4,870,000.00	0	100
24	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00	0	100
<b>25</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,460,000.00</b>	<b>18,460,000.00</b>	<b>0</b>	<b>100</b>
26	Багаж, техник, хэрэгсэл	7,300,000.00	7,300,000.00	0	100
27	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	750,000.00	750,000.00	0	100
28	Урсгал засвар	10,410,000.00	10,410,000.00	0	100
<b>29</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,176,300.00</b>	<b>1,060,000.00</b>	<b>116,300.00</b>	<b>90</b>
30	Дотоод албан томилолт	1,176,300.00	1,060,000.00	116,300.00	90
<b>31</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,576,700.00</b>	<b>13,576,700.00</b>	<b>0</b>	<b>100</b>
32	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,480,000.00	8,480,000.00	0	100
33	Тээврийн хэрэгслийн татвар	810,200.00	810,200.00	0	100
34	Тээврийн хэрэгслийн оношилгоо	286,500.00	286,500.00	0	100
35	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	4,000,000.00	0	100
36	Бараа үйлчилгээний бусад зардал	736,600.00	736,600.00	0	100
37	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	736,600.00	736,600.00	0	100
<b>38</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>143,214,800.00</b>	<b>143,214,800.00</b>	<b>0</b>	<b>100</b>
<b>39</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>143,214,800.00</b>	<b>143,214,800.00</b>	<b>0</b>	<b>100</b>
40	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0	100
41	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,675,700.00	63,675,700.00	0	100
42	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,239,100.00	45,239,100.00	0	100
43	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,300,000.00	33,300,000.00	0	100
<b>44</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,597,635,000.00</b>	<b>1,597,518,700.00</b>	<b>116,300.00</b>	<b>99.9</b>
<b>45</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,595,034,000.00</b>	<b>1,592,249,200.00</b>	<b>2,784,800.00</b>	<b>99.8</b>
46	Улсын төсвөөс санхүүжих	1,595,034,000.00	1,592,249,200.00	2,784,800.00	99.8
<b>47</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,601,000.00</b>	<b>5,269,500.00</b>	<b>-2,668,500.00</b>	<b>202</b>
48	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,601,000.00	5,269,500.00	-2,668,500.00	202
<b>49</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>50</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100</b>

51	Төсвийн байгууллага	1	1	0	100
<b>52</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>56</b>	<b>52</b>	<b>4</b>	<b>92.8</b>
53	Удирдах ажилтан	1	1	0	100
54	Гүйцэтгэх ажилтан	53	49	4	92.4
55	Үйлчлэх ажилтан	2	2	0	100
<b>56</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>56</b>	<b>52</b>	<b>4</b>	<b>92.8</b>
57	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	54	50	4	92.5
58	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2	0	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0	0	0	
2	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0	1,364,250.00	(1,364,250.00)	
3	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	0	1,364,250.00	(1,364,250.00)	
4	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	0	1,364,250.00	(1,364,250.00)	
5	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0	530,000.00	(530,000.00)	
6	Тээвэр (шатахуун)	0	530,000.00	(530,000.00)	
7	Эд хогшил худалдан авах	0	834,250.00	(834,250.00)	
8	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0	834,250.00	(834,250.00)	
9	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0	1,365,300.00	(1,365,300.00)	
10	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0	1,365,300.00	(1,365,300.00)	
11	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	1,365,300.00	(1,365,300.00)	
12	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0	0	0	
13	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0	0	0	
14	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0	0	0	
15	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	0	0	0	
16	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	56	56	0	
17	Удирдах ажилтан	1	1	0	
18	Гүйцэтгэх ажилтан	53	53	0	
19	Үйлчлэх ажилтан	2	2	0	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Сум дундын Цагдаагийн хэлтэс /цаашид Сайхан сумын Цагдаагийн хэлтэс гэх/ нь “Нийтийн хэв журмыг сахиулан хамгаалах, удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж шуурхай байдлыг хангах” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх,
- Нийтийн хэв журам хамгаалах,
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- ЦЕГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/340 дүгээр тушаалаар цалингийн зэрэглэлд өөрчлөлт оруулсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Сайхан сумын Цагдаагийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд ЦЕГ-ын Дотоод хяналт-аюулгүй байдлын газар хяналт тавьж ажилладаг бөгөөд Цагдаагийн байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2023 оны 02 дугаар сард төлөвлөгөөт иж бүрэн шалгалт хийж, санхүү, үйл ажиллагааны чиглэлээр 7

үүргийн хэрэгжилтийг хангаж, тооцож ажиллахыг даалгасны дагуу Сайхан сумын Цагдаагийн хэлтсээс биелэлтийг гаргаж хугацаандаа тайлагнасан байна.

Тус газраас төлөвлөгөөт иж бүрэн шалгалт хийсэн дүнд үндэслэн гүйцэтгэлийн шалгалтыг 2024 оны 02 дугаар сард хийж, өгсөн үүргийн биелэлт, үр дүн “Сайн” үнэлгээтэй хэрэгжсэн гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын Цагдаагийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсон байна.

Иймд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь *“Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”* гэсэн заалтын дагуу нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах нь зүйтэй юм.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сайхан сумын Цагдаагийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,313,812.0 мянган төгрөгөөр буюу 411.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,533.2	30,457.2	19,924.0
Авлага	3,675.5	3,776.5	101.0
Бараа материал	76,959.9	85,719.8	8,759.9
Үндсэн хөрөнгө	470,693.3	2,755,720.4	2,285,027.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>561,861.9</b>	<b>2,875,673.9</b>	<b>2,313,812.0</b>
Өр төлбөр	43.0	253.4	210.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	561,818.9	2,875,420.5	2,313,601.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>561,861.9</b>	<b>2,875,673.9</b>	<b>2,313,812.0</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 30,457.2 мянган төгрөг болж 19,924.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ЦЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу цалингийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардлаас нийт 25,509.0 мянган төгрөгийг Ахмадын сангийн 100130912503 тоот дансанд төвлөрүүлсэн,
- Бараа материалын дансны үлдэгдэл 85,719.8 мянган төгрөг болж 8,759.9 мянган төгрөгөөр өссөн нь ЦЕГ-аас 15,151.7 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан, нас дэвшилтийн орлогоор 1,938.2 мянган төгрөгийн мал хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 62,546.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 62,672.8 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулж Сайхан сумын Цагдаагийн хэлтсийн даргын 2023 оны 09 дүгээр сарын 15 –ний өдрийн А/29 дүгээр тушаалаар 8,203.7 мянган төгрөгийн бараа материал акталансантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,755,720.4 мянган төгрөг болж өмнөх оноос 2,285,027.1 мянган төгрөгөөр өссөн нь, төсвийн хөрөнгөөр 3,540.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ЦЕГ-ийн шийдвэрээр 2,313,558.2 мянган төгрөгийн үнэ бүхий компьютер, принтер үнэ төлбөргүйгээр, Цагдаагийн хэлтсийн шинэ барилгыг ашиглалтад хүлээн авсан болон Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023-12-20 -ний өдрийн №32 дугаар тогтоолоор 25,477.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актлан 175,309.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,347,023.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,000.0 мянган төгрөг, нийт 1,350,023.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 365,647.8 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 2,954.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж, байр ашиглалттай холбоотой зардлыг 50,820.0 мянган төгрөгөөр, бараа материалын зардлыг 50,092.6 мянган төгрөгөөр, норматив зардлыг 9,847.5 мянган төгрөгөөр тавилга эд хогшил урсгал засварын зардлыг 282,510.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 13,469.8 урсгал шилжүүлгийг 1,900.0 мянган төгрөгөөр бууруулсан нийт дүнгээр 408,640.2 мянган төгрөгөөр бууруулж, мянган **1,309,985.9** мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд хийгдсэн төсвийн тодотгол, зохицуулалтаар цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 109,992.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 31,272.2 мянган төгрөг, норматив зардал 5,270.0 мянган төгрөг, бусад шилжүүлгийг 141,114.8 мянган төгрөг төсвийг нийт 287,649.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **1,597,635.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр **1,597,635.0** мянган төгрөгийн төсөв баталж, үйл ажиллагааны орлогоос 2,601.0 мянган төгрөг, улсын төсвөөс 1,595,034.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлогоос 2,601.0 мянган төгрөг, улсын төсвөөс **1,597,635.0** мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,594,850.2** мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь “Цагдаа” хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардлыг 2,784.8 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
<b>А</b>	<b>Цагдаа</b>	<b>1,467,625.0</b>	<b>1,464,840.2</b>	<b>2,784.8</b>	<b>99.8</b>
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,322,430.2	1,319,645.4	<b>2,784.8</b>	<b>99.8</b>
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	143,214.8	143,214.8	-	100
3	Байцаан шийтгэх ажиллагаа	1,980.0	1,980.0	-	100
<b>Б</b>	<b>Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах</b>	<b>130,010.0</b>	<b>130,010.0</b>	-	<b>100</b>
3	Үндсэн үйл ажиллагааны зардал	<b>130,010.0</b>	<b>130,010.0</b>	-	100
	<b>Дүн</b>	<b>1,597,635.0</b>	<b>1,594,850.2</b>	<b>2,784.8</b>	<b>99.8</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130912401 тоот дансанд үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 1,365.3 мянган төгрөгийг хүлээн авч, 834.2 мянган төгрөгийг хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд, 530.0 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд Сайхан сумын Цагдаагийн хэлтэст шатахуун худалдан авах [СЭАССДСДЦХ/202301001/02/01](#) дугаартай, 28,108.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг *Тендер шалгаруулалтын онцгой журам, Харьцуулалтын арга* 2023 оны 03 дугаар сарын 27, 05 дугаар сарын 16-ны өдөр [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудсанд зарласан боловч санал ирүүлсэн оролцогч байхгүй тул ШУНХЛАЙ ПЕТРОЛИУМ ХХК-тай шатахуун худалдан авах гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын Цагдаагийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Ундраа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын Цагдаагийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 46/3-83 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,065,375.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,653.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны төсөв материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,617,303.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 16,173.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад ЦЕГ-ын даргын 2023 оны 2/352, Санхүү, ар талын албаны даргын 2023 оны 16/2918 дугаар албан бичгүүдээр *“Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон “Ахмадын сан”-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах”* гэж үүрэг, ажлын чиглэл өгсний дагуу 3,113.3 мянган төгрөгийн шатахуун худалдан авч нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь *“нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.*

Тайлант хугацаанд Сайхан сумын Цагдаагийн хэлтсийн мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллээс дараах 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 7 дугаар сар
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1 дүгээр сард тус тус мэдээлэл хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,206.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	5,206.0	1	5,206.0	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>5,206.0</b>	<b>1</b>	<b>5,206.0</b>	<b>100</b>

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сайхан сумын Цагдаагийн хэлтсийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд: ЦЕГ-ын даргын 2023 оны 2/352, Санхүү, ар талын албаны даргын 2023 оны 16/2918 дугаар албан бичгүүдээр “Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон “Ахмадын сан”-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах” гэж үүрэг, чиглэл өгсний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

- Тээвэр, шатахууны зардлын хэмнэлт **3,113.3** мянган төгрөгийн шатахуун худалдан авч, нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 7 дугаар зүйлийн 7.7 дахь “... төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд ... **төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ**”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “**нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх**” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

- Цалингийн хэмнэлт **25,509.0** мянган төгрөгийг “Ахмадын сан”-ийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах **хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана**” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд дээрх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж батлуулсны үндсэн дээр санхүүжүүлэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 4,845.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

### 5.2 Зөвлөмж

#### 1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдэлттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан нийт 4,845.0 мянган төгрөгийн хүнсний материалын зарлагыг зарцуулалтын өдөрлөг зэрэг анхан шатны баримтгүйгээр нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр нь шаардах хуудас бичиж сард нэг удаа зарлагадсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын ... нягтлан бодогч нь ...хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 3.6 дахь “**Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед** уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч **шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ.**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.1 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх, хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр баримтжуулан бүртгэж байх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>1</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

/мянган төгрөгөөр/

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан	1	4,845.0					1	4,845.0				
Дүн	1	4,845.0					1	4,845.0				

/мянган төгрөгөөр/

Үүнээс

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-			-	1
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>-</b>	<b>1</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
<b>Дүн</b>						
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>-</b>	<b>1</b>